



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Солонго дулааны станц” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/06/-НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас: 99177546      Цахим хаяг: <a href="mailto:Vujinkhandj@audit.gov.mn">Vujinkhandj@audit.gov.mn</a>	
Аудитор Г.Энхдэлгэр	
Утас: 70484030      Цахим хаяг: <a href="mailto:Enkhdelgerg@audit.gov.mn">Enkhdelgerg@audit.gov.mn</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	7
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.8 Аудитын гол асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 03. 15 № 164  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Солонго дулааны станц” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Солонго дулааны станц” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07122446

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.ТҮВШИНБАЯР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>187,103,989.53</b>	<b>251,584,781.80</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>815,217.88</b>	<b>646,681.32</b>
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	12,468.00	-
31110	Төгрөг	12,468.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	802,749.88	646,681.32
31210	Төгрөг	802,749.88	646,681.32
31213	Арилжааны банк дахь харилцах	802,749.88	646,681.32
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>20,496,365.86</b>	<b>26,629,120.50</b>
33500	Бусад авлага	20,496,365.86	26,629,120.50
33510	Байгууллагаас авах авлага	6,984,207.86	26,629,120.50
33520	Хувь хүмүүсээс авах авлага	13,512,158.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>149,001,200.00</b>	<b>149,001,200.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	149,001,200.00	149,001,200.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>16,791,205.79</b>	<b>75,307,779.98</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,834,836.59	53,279,999.99
35400	Хангамжийн материал	4,956,369.20	22,027,779.99
35410	Бичиг хэргийн материал	442,169.20	1,026,094.00
35420	Аж ахуйн материал	4,514,200.00	20,768,177.20
35440	Түлш, шатах тослох материал	-	233,508.79
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,193,108,326.03</b>	<b>10,260,624,094.45</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,193,108,326.03</b>	<b>10,260,624,094.45</b>
39200	Биет хөрөнгө	5,157,237,076.03	10,224,992,844.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,161,301,345.10	9,412,869,961.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(54,137,562.08)	(206,666,032.21)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,146,366,738.00	1,190,666,737.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,517,353.32)	(174,619,840.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,318,900.00	3,068,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(94,991.67)	(326,881.67)
39300	Биет бус хөрөнгө	35,871,250.00	35,631,250.00
39301	Програм хангамж	960,000.00	960,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(288,750.00)	(528,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,200,000.00	35,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,380,212,315.56</b>	<b>10,512,208,876.25</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>213,866,490.69</b>	<b>244,208,848.64</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>98,266,953.73</b>	<b>207,008,001.45</b>
41300	Өглөг	98,266,953.73	207,008,001.45
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	764,799.00	-
41360	Бусад өглөг	97,502,154.73	207,008,001.45
41361	Байгууллагад төлөх өглөг	70,705,154.44	131,721,890.53
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	550,400.00	22,026,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	24,631,191.99	39,117,474.98
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	1,615,408.30	14,142,635.94
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>115,599,536.96</b>	<b>37,200,847.19</b>
42200	Урт хугацаат зээл	115,599,536.96	37,200,847.19
42210	Төгрөг	115,599,536.96	37,200,847.19
42242	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	115,599,536.96	37,200,847.19
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,166,345,824.87</b>	<b>10,268,000,027.61</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,166,345,824.87</b>	<b>10,268,000,027.61</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын өмчлөлт/	-	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	5,337,744,183.10	10,589,312,799.10
51200	Хуримтлагдсан үр дүн	(171,398,358.23)	(321,312,771.49)
51210	Өмнөх үеийн үр дүн	(93,002,611.40)	(171,398,358.23)
51220	Тайлант үеийн үр дүн	(78,395,746.83)	(149,914,413.26)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=III-IV</b>	<b>5,380,212,315.56</b>	<b>10,512,208,876.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,205,902.84	(52,927,521.02)
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,205,902.84	(52,927,521.02)
120	Нийтлэг татварын бус орлого	6,205,902.84	(52,927,521.02)
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	469,004,797.03	728,759,222.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	462,798,894.19	821,686,743.02
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	-	-
122	Тусламжийн орлого	-	-
122001	Хандив тусламж /дотоод/	-	40,000,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	84,601,649.67	96,986,892.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,601,649.67	96,986,892.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,601,649.67	96,986,892.24
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,601,649.67	96,986,892.24
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	80,406,865.71	93,695,082.01
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	4,194,783.96	2,631,810.23
210813	Бусад зардал /ТӨҮГ/	-	660,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(78,395,746.83)	(149,914,413.26)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(78,395,746.83)	(149,914,413.26)
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,084,560,623.00	(93,002,611.40)	991,558,011.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,084,560,623.00	(93,002,611.40)	991,558,011.60
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	4,253,183,560.10	-	4,253,183,560.10
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	(78,395,746.83)	(78,395,746.83)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,337,744,183.10	(171,398,358.23)	5,166,345,824.87
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,337,744,183.10	(171,398,358.23)	5,166,345,824.87
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,337,744,183.10	(171,398,358.23)	5,166,345,824.87
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	5,251,568,616.00	-	5,251,568,616.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	(149,914,413.26)	(149,914,413.26)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,589,312,799.10	(321,312,771.49)	10,268,000,027.61

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>502,186,281.90</b>	<b>842,533,071.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>502,186,281.90</b>	<b>842,533,071.56</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>502,186,281.90</b>	<b>802,533,071.56</b>
120009	Бусад орлого	5,948,712.38	102,562.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	496,237,569.52	802,430,509.56
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>-</b>	<b>40,000,000.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	-	40,000,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>464,291,270.18</b>	<b>718,570,479.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>464,291,270.18</b>	<b>718,570,479.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>464,291,270.18</b>	<b>718,570,479.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>115,771,984.64</b>	<b>152,088,700.00</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	115,771,984.64	152,088,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,304,810.00</b>	<b>38,264,377.64</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	35,304,810.00	38,264,377.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>77,989,612.00</b>	<b>127,278,015.86</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	77,989,612.00	127,278,015.86
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>186,226,480.00</b>	<b>338,034,738.00</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	5,782,800.00	325,766,020.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	180,443,680.00	12,268,718.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,998,383.54</b>	<b>62,904,648.31</b>
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	3,944,783.96	699,371.68
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	33,653,089.58	36,239,002.62
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	210,000.00
<b>210818</b>	<b>Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/</b>	<b>11,400,510.00</b>	<b>25,756,274.01</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>37,895,011.72</b>	<b>123,962,591.75</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,229,900.00</b>	<b>44,299,999.99</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,229,900.00</b>	<b>44,299,999.99</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	3,229,900.00	44,299,999.99
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,229,900.00	44,299,999.99
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(3,229,900.00)</b>	<b>(44,299,999.99)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(34,400,463.04)</b>	<b>(79,831,128.32)</b>
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>34,400,463.04</b>	<b>79,831,128.32</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
250002	Зээл, ерийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	34,400,463.04	79,831,128.32
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>264,648.68</b>	<b>(168,536.56)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	550,569.20	815,217.88
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	815,217.88	646,681.32

**2.6 Үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө, гүйцэтгэл**

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Үйл ажиллагааны орлого	706,135,318.00	728,759,222.00
Бусад орлого		40,000,000.00
<b>ОРЛОГО</b>	<b>706,135,318.00</b>	<b>768,759,222.00</b>
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
<b>1.3 Нийт ашиг</b>	<b>706,135,318.00</b>	<b>768,759,222.00</b>
Нүүрсний зардал	307,281,600.00	322,618,113.12
Нүүрс тээврийн зардал	11,152,171.00	10,461,454.54
Усны зардал	5,755,200.00	17,282,591.00
Цахилгааны зардал	93,883,500.00	100,287,868.39
Шатахууны зардал	3,375,000.00	1,920,704.60
Сэлбэг хэрэгсэл	14,280,000.00	6,355,391.83
Урсгал засвар	3,144,000.00	2,798,960.75
Үндсэн ба нэмэгдэл цалин	215,616,960.00	184,460,701.00
Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	36,285,029.00	28,578,671.26
Элэгдлийн зардал	174,791,566.00	229,102,847.57
Албан томилолт	1,316,000.00	200,000.00
Бичиг хэргийн зардал	700,000.00	543,773.00
Харилцаа холбоо	1,352,500.00	540,000.00
Хөдөлмөр хамгаалал	4,130,000.00	585,723.98
Багаж хэрэгсэл		-
Гүйцэтгэх удирдлагын зардал		
Борлуулалт маркети нгийн зардал	300,000.00	
Зохицуулалтын үйлчилгээний хөлс	3,000,000.00	2,345,024.00
Гадны үйлчилгээний хөлс	11,500,000.00	7,400,000.00
Тохижилтын зардал	4,241,400.00	
Сургалтын зардал	1,120,000.00	
У/а бусад зардал		
банкны шимтгэл		
Бусад		
<b>1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>893,224,926.00</b>	<b>915,481,825.04</b>
<b>1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/</b>	<b>(187,089,608.00)</b>	<b>(146,722,603.04)</b>
<b>Үндсэн бус үйл ажиллагаа</b>		
Үл хөдлөх хөрөнгийн татвар	31,865,688.00	
Агаарын бохирдлын татвар	2,845,200.00	
Газрын төлбөр	400,000.00	400,000.00
Ажиллагсдын нийгмийн зардал	2,660,000.00	660,000.00
Урт хугацаат зээлийн хүүгийн зардал	2,131,809.00	2,131,810.23
үндсэн бус у/а зардал	39,902,697.00	3,191,810.23
<b>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдал</b>	<b>(39,902,697.00)</b>	<b>(3,191,810.23)</b>
<b>3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал</b>	<b>(226,992,305.00)</b>	<b>(149,914,413.27)</b>
Татвараас чөлөөлөгдөх зардал		
Татвар төлөх ашиг алдагдал	(226,992,305.00)	(149,914,413.27)
3.1 Орлогын татварын зардал		
<b>4. Татварын дараах ашиг алдагдал</b>	<b>(226,992,305.00)</b>	<b>(149,914,413.27)</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Солонго дулааны станц” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Солонго дулааны станц” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 8 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Солонго дулааны станц” ААТҮГ нь дулаан үйлдвэрлэж, дулаанаар хангах, түгээх үйл ажиллагааны чиглэлтэй байгууллага юм.

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус Үйлдвэрийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Солонго дулааны станц” ААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 547.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 918.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга Байгууллагын үйл ажиллагаа

Үйлдвэрийн газрын зорилго нь өөрийн явуулах гэж буй үйлчилгээний чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж, харьяалах нутаг дэвсгэртээ үйлчилгээнийхээ хүрээг тэлж, хэрэглэгчдийг норм, стандартын шаардлагад нийцсэн жигд найдвартай үйлчилгээгээр хангаж, үр ашигтай ажиллах явдал юм.

Үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь холбогдох хууль тогтоомж болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүргийн хэмжээнд болон үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлээр байнга тасралтгүй хангахын зэрэгцээ дотоодын хяналтыг хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 1 статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Солонго дулааны станц” ААТҮГ-ыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ын бүрэлдэхүүн томилогдоогүй. Байгууллагын ажилчдын цалингийн жишгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталж өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд шилжүүлэн авсан бүх хөрөнгийг бүртгэл тооцоонд тусгаж, арчлалт, хадгалалт, хамгаалалтыг хийх арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу энэ төрлийн зардал гаргаагүй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 70 дугаар тогтоолоор тус үйлдвэрийн газрын бүтэц орон тоо, цалингийн жишгийг шинэчлэн баталсан.
- Засгийн газрын 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар тусгасан.

### 3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	815.2	646.7	(168.5)
БХХО			
Авлага	20,496.4	26,629.1	6,132.7
Урьдчилгаа	149,001.2	149,001.2	0
Бараа материал	16,791.2	75,307.8	58,516.6
Үндсэн хөрөнгө	5,192,437.1	10,260,192.8	5,067,755.8
Биет бус хөрөнгө	671.2	431.2	240.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>5,380,212.3</b>	<b>10,512,208.9</b>	<b>5,131,996.6</b>
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг	98,267.0	207,008.0	108,741.0
Урт хугацаат өр төлбөр	115,599.5	37,200.8	(78,398.7)
Эздийн өмч	5,166,345.8	10,268,000.0	5,101,654.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,380,212.3</b>	<b>10,512,208.9</b>	<b>5,131,996.6</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 0.6 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд төрөөс үзүүлсэн хөнгөлөлттэй холбоотой ДҮТ-өөс 20.1 сая төгрөг, "Хөх бүрдний эх" ХХК-с халаалтын авлага 6.5 сая төгрөг, нийт авлага 26.6 сая төгрөг байна. Тайлант онд төрөөс үзүүлсэн хөнгөлөлттэй холбоотой ДҮТ-өөс авах авлага нэмэгдсэн нь авлагын өсөлтөнд нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд 6.5 сая төгрөгийн авлага нь он дамнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75.3 сая төгрөг болж 58.5 сая төгрөгөөр өссөн нь нүүрс болон хангамжийн материалын худалдан авалтаас зарцуулалт бага байгаатай

холбоотой байна. Тайлант онд 389.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 330.9 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Үнэ төлбөргүй бараа материал хүлээн аваагүй.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,260.2 сая төгрөг болж 5,067.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр цахилгааны хаалттай дэд өртөө, дулаан хангамжийн магистраль шугам, цахилгааны магистраль шугам, гадна холбооны шугам зэрэг 5,251.6 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч бүртгэсэн. Мөн төсвийн хөрөнгөөр 44.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж бэлтгэсэн. Хөрөнгө акталж устгаагүй.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 207.0 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 2019 онд 3 жилийн хугацаатай ЖДҮ хөгжүүлэх сангаас 150.0 сая төгрөгийн зээлийг Онцгүй байдлын газрын чиглэлд дулааны шугам сүлжээ барьж байгуулах зорилгоор авсан. Үндсэн зээл, хүү хугацаандаа төлөгдөөд тайлант оны эцэст 37.2 сая төгрөг болсон байна.

### **3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Солонго дулааны станц” ААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 69 дүгээр тушаалаар “Солонго дулааны станц” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 706.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 933.1 сая төгрөгөөр, 227.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд төлөвлөөгүй.

Гүйцэтгэлээр 768.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 918.7 сая төгрөгийн зардал гарган, 149.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 768.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 62.6 сая төгрөг буюу 109 хувиар давсан нь шинээр айл өрх, албан байгууллагуудын холболтууд нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 933.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 918.7 сая төгрөг буюу 2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь үл хөдлөх хөрөнгийн татвар төлөөгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 149.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 92.4 сая төгрөгөөр бага байгаа нь аймгаас хандиваар 40.0 сая төгрөг хүлээн авч, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 31.9 сая төгрөгөөр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр гараагүй байгаа зэргээс шалтгаалж алдагдал буурсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аудитын хамрах хүрээнд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 1,696.6 сая төгрөгийн 99 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гүйлгээ бүрт төлбөрийн баримтаар буюу и баримт шивүүлж баримтын бүрдэл болгох үүрэгтэй.

Тайлант хугацаанд 55.4 сая төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт аваагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28.2-т “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ.” гэсэн заалттай нийцээгүй байна.

### 3.9.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тендерт шалгараагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас 87.2 сая төгрөгийн нүүрсний худалдан авалт хийсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 166.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1.5 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны зарцуулалтыг үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 151.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.6 сая төгрөгийн алдааг залруулж, 150.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### 4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

### 4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.2.3 Албан шаардлага

Төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 1.6 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагаас авах 6.5 сая төгрөгийн он дамнасан авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант хугацаанд 55.4 сая төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт аваагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх хөрөнгийн дүн санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүнгээс 10,051.1 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.2. "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.", Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 8.2.Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ:8.2.3.хувь нийлүүлсэн хөрөнгө” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тендерт шалгараагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас 87.2 сая төгрөгийн нүүрсний худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

#### 4.2.4 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
	"Солонго дулааны станц" ААТҮГ	5	8.7	1	0.6			4	8.1		
<b>Дүн</b>		5	8.7	1	0.6			4	8.1		
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
	"Солонго дулааны станц" ААТҮГ	2	142.6					2	142.6		
<b>Дүн</b>		2	142.6					2	142.6		
<b>Нийт дүн</b>		7	151.3	1	0.6			6	150.7		